

Чанарын ба тоон судалгаан дахь этнографийн үүрэг: Монгол дахь хээрийн судалгаа

Б.Цэвэлмаа

МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн
магистрант

tsmme0528@gmail.com

Хураангуй

Тус өгүүлэлд антропологийн судалгааны үр дүнгээс онолын түвшинд дүгнэлт гарах хүртэл туулдаг арга замыг тайлбарлахыг зорьлоо. Энэ нь судалгааны арга зүй практикт хэрхэн өрнөдгийг ойлгоход илүү дөхөм болох учиртай юм. Үүнд Хэнтий болон Завхан аймагт 1) бэлчээрийн мал аж ахуй, 2) эдийн засгийн шийдвэр, нийгмийн сүлжээ сэдвээр явуулсан урт хугацааны судалгааны 2023 оноос хойших дата, мэдээллийг голлон ашиглав. Тэр дундаа этнографи жишээ, хээрийн судалгааны явцад тулгарсан асуудал зэргийг хээрийн тэмдэглэлээсээ голлон орууллаа. Дээрх судалгааны үндсэн арга зүй нь этнографийн ажиглалт, ярилцалгын хүрээнд хийгдсэн. Эдгээр судалгааны материалд түшиглэн сүлжээний торлог зурах байдлаар нийгмийн бүлгүүдийг тодорхойлох арга зүйг илүү дэлгэрэнгүй өгүүлэх билээ. Үүнд тэдгээрийн харилцааны хэлбэр, гишүүнчлэл, зохицуулагч, шийдвэр гаргагчийг илрүүлэх гэхчлэн онолын түвшинд дүгнэлт гарах хүртэл туулах арга замыг нарийн тайлбарлана. Ураг төрөл, газар нутагт суурилсан нийгэм, нийгмийн бүлгүүдийн тухай маргаан, түүнээс үүдэн гарах олонхи, цөөнх, бүлгүүдийн харилцаа, нутгийн хүмүүс хамтарч ажилладаг эсэх, хувийн болон нийтийн өмчийн маргаан зэрэг олон чиглэлээр судлав. Антропологийн хээрийн судалгаа нь урт хугацааны, дасан зохицох, системтэй эрэл хайгуул бөгөөд тодорхой асуудал эсвэл сэдвийг өөрийн биеэр оролцож, ажиглаж, ойлгох нь чухал ач холбогдолтой байдаг. Үүний зорилго нь тухайн асуудлын нэг хэсэг болсон, түүнд хувь нэмэр оруулж буй эсвэл түүний нөлөөлөлөөс хүртэж буй хүмүүсийн өнцгөөс ойлгоход оршино. Бид тэдний янз бүрийн итгэл үнэмшлийг, байр суурийг ойлгохыг эрмэлздэг. Мөн хүмүүсийн хэлдэг зүйл болон тэдний бодит үйлдэл хоёул антропологийн судалгаанд адилхан чухал ач холбогдолтой байдаг.

Түлхүүр үг: этнографийн ажиглалт, чанарын судалгаа, сүлжээний торлог

Судлагдсан байдлын тойм

Нийгмийн сүлжээний онолын (HCO) цөм ойлголт нь адил шинжээр холбогдох байдал (Lazarsfeld & Merton 1954), гурвал үүсэх хандлага (Granovetter 1973), давуу эрхтэй холболт (preferential attachment) (Barabási & Albert 1999) зэрэг хүмүүс хоорондоо холбоос үүсгэх механизм мөн төвлөрөл (Freeman 1979) ба зуучлал (Burt 1992) зэрэг байр суурийг хэмждэг. Грановеттер (1973) сул холбоос нь шинэ

мэдээлэлд хүрэх суваг болдогийг харуулсан бол Бөрт (1992) бүтцийн цоорхойг нөхөж, гэтлэн гарах нь өрсөлдөх давуу тал өгдөгийг баталсан. Колеман (1988) болон Бордиу (1986) нар сүлжээний нөөц ба итгэлцлийг нийгмийн капитал гэж тодорхойлсон бөгөөд энэ нь заримдаа хаалттай сүлжээ итгэлцлийг тогтвортой байлгахад, заримдаа бат бөх холбоос, давуу тал бий болгоход тусалдаг гэж үзжээ.

Марк Грановеттерийн (1973) хүмүүсийн хооронд үүсэж буй сул холбоос (ураг төрөл, дотно найз нөхдөөс өөр хүмүүстэй үүсэж буй) хэрхэн мэдээлэл, боломж, шинэ санааг авчирч, нийгмийг урагшлуулдаг тухай санаагаар баяжуулав. Мөн аливаа нийгэм соёл нь эдийн засгийн харилцааг өөртөө багтаадаг гэх онолын хүрээнд "эдийн засгийн харилцаа нь дан ганц өөрт ашигтай байх тооцоолол биш бөгөөд нийгмийн сүлжээ, хүмүүс хоорондын харилцан итгэлцэлд суурилсан байдаг" (Granovetter 1973) гэх үзэл санаанд тулгуурлах болжээ.

Судалгааны арга зүйн хувьд нийгмийн сүлжээний дүрслэлээс эхлэн статистикийн нарийн загвар хүртэл өргөжижээ. Экспоненциал санамсаргүй графийн загварууд (Exponential Random Graph Models, ERGM) нь холбоос үүсэх орон нутгийн процессийг тайлбарладаг (Frank & Strauss 1986; Wasserman & Pattison 1996; Robins et al. 2007). Өөрөөр хэлбэл орон нутгийн иргэдийн малчин, тариачин, залуу байх, уяач, өгөөмөр, зарчимч гэх мэт зарим нийтлэг шинж чанараараа хүмүүс нийлж сүлжээ үүсгэж байгааг тайлбарладаг.

Нөгөө талаар хоёр хүн холбоо үүсгэхэд дундын найз нөхөд, нийтлэг шинж хэрхэн нөлөөлж байгааг судалдаг. Харин стохастик үйлдэлч төвтэй загварууд (Stochastic Actor-Oriented Models, SAOM) нь сүлжээ ба зан үйлийн хам өөрчлөлтийг загварчилдаг (Snijders 2001; Snijders & Steglich 2010). Энэ нь сүлжээ хэрхэн бий болж, дуусч байгааг оролцогчдын сонголт, зан үйлийн өөрчлөлтэй холбон тайлбарладаг. Мөн сүлжээнд оролцож буй хүн нь нэгэн зэрэг гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олон, онлайн гэх мэт олон сүлжээнд оролцож байгааг давхарга бүрээр нь авч үзэж, тэднийг хооронд нь холбож давхараажсан бүтцийг тодорхойлох шаардлагатай. Гэсэн хэдий ч тэдгээр сүлжээний хил заагийг тогтоох, бүх холбоосыг бүртгэх боломж хомс, сүлжээнээс хамаарч хувь хүний зан үйл өөрчлөгдсөн үү эсвэл оролцогч өөрийн сонголтоор тухайн сүлжээг анхнаасаа сонгосон уу гэх зэргийг судлах шаардлага тавигдаж байна. Ан тэргүүтэй судлаачид (2022) сүлжээнд оролцогчдын дундаас олон хүнтэй холбогдсон төвийн байрлалтай хүмүүс илүү итгэлтэй эх сурвалж болдог тул мэдээллийн дүн шинжилгээ хийхдээ тэр хэсэгт илүү ач холбогдол өгч, этнографийн судалгаандаа ч мөн тэр хэсгийг илүү анхаарах шаардлагатай гэж үзсэн. Ингэснээр этнографи, чанарын болон тоон судалгаанд сүлжээний торлогийг илүү үр дүнтэй ашиглах боломжтой болж байгаа юм.

Монголд хийгдсэн судалгаануудаас Снийт (1993) пост-социалист Монгол улсад хөдөөгийн ард иргэд хэрхэн ураг төрөл ба зан

үйлийн холбоон дээр түшиглэн амьдарч байгааг судалсан. Бямбажав (2010) монголчууд албан ёсны бүлгээс илүү албан бус сүлжээг илүүд үздэг ч, боловсрол, статус, газар зүйн ялгаанаас хамаарч харилцан адилгүй байгааг тогтоожээ. И.Бямбабаатар болон Иех (2016) нар арга зүй, онолын чиглэлээр хувь нэмэр оруулсан байдаг. Арга зүйн хувьд, тэд эго төвтэй сүлжээний шинжилгээг (egocentric network analysis) этнографитай хослуулан ашигласнаар нуугдмал итгэлцэл ба эрх мэдлийн харилцааны түвшинг ил болгож, сүлжээг албан ёсны институцийн бүлгээр хязгаарлан ойлгож болохгүй гэж үзжээ. Тэд Баянжаргаланд 15 малчны сүлжээг зурж, 400 зангилаа, 734 харилцан холбоосыг бүртгэн, нүүр тулсан болон утсаар харилцах давтамжаар холбоосын хүчийг шинжлэсэн. Судалгаагаар нийгмийн сүлжээ нь малчдын бүлэг (HG), бэлчээр ашиглагчдийн хэсэг (PUG) гэх мэт албан ёсны бүлгийн хил хязгаарийг давж, аймаг, нийслэл Улаанбаатар луу суна тэлж байгааг тогтоожээ. Түлхүүр зуучлагчид эгогийн сүлжээнүүдийг холбон, институцийн загварт харагдахгүй байгаа эрх мэдлийн урсгалыг ил болгосон юм. Агуулгын хувьд, итгэлцэл ба нийгмийн капитал нь институцийн зохиомол загвараар автоматаар бий болдоггүй, харин өмнө нь бүрэлдсэн хүн, нийгэм, байгалийн харилцаа холбоонд шингэж, орон зай болон нийгмийн ангиллыг дамнан тогтдог болохыг нотолсон байна. Малчдын бүлгийн гишүүдийн 60 хувь нь эгогийн итгэмжлэгдсэн мэдээллийн сүлжээнд ордоггүй байсан бөгөөд зарим тохиолдолд удирдагчид төслийн ашиг тусыг өөрийн ойрын хүрээлэлд төвлөрүүлснээр албан ёсны бүлэг, институцийн итгэлцэл бүр доройтсон гэж үзжээ. Ийнхүү И.Бямбабаатар болон Иех нарын судалгаа эго төвтэй шинжилгээ, этнографи хослох үед бодит эрх мэдэл, найдвартай байдал хэрхэн илэрдэгийг харуулсан бөгөөд харилцааны далд бүтцийг судалжээ.

Тэдний дүгнэлт нь Монголын өмнөх судалгаатай уялдаж байна. Жишээлбэл, Снийт (1993) пост-социализмын эрх мэдлийн сүлжээг, Мөрфи (2015) ураг төрлийн харилцааны цаадах эрх мэдэл ба хөдөлмөрийн харилцаа, Аптон (2008), Фернандез-Гименез (2015), Уламбаяр (2017; 2019) нарын бэлчээрийн хамтын зохицуулалт дахь нийгмийн капиталын тухай судалгаатай уялдаж байгаа юм. Эдгээртэй нийцүүлэн Бямбабаатар болон Иехийн судалгаа нь итгэлцэл, нийгмийн капитал нь хоорондоо харилцан хамааралтай төдийгүй улс төрийн шинжтэй бөгөөд нийгмийн сүлжээ нь институцийн бүтэцтэй автоматаар нийцдэггүйг онолын хувьд баталж байна.

Сүлжээ сайн сайхан байдалд ихээхэн нөлөө үзүүлдэг. Отгон (2023) зэрэг судлаач өндөр настны нийгмийн сайн сайхан байдал нь найз нөхдийн харилцаа, уулзалтын давтамжаас ихээхэн хамаардаг болохыг тогтоов. Харьцуулсан судалгаагаар, Редхед (2022) Колумбын тосгонд нөхөрлөл, хосын сонголт нь адил шинжээр холбогдох байдал (homophily) ба харилцан туслалцах байдал (reciprocity)-д тулгуурладгийг, Симпсон болон Повер (2023) Энэтхэгийн Тамил

тосгонд эмэгтэйчүүд илүү хамтын стратеги хэрэглэдэг боловч тэдний сүлжээний бүтэц эрэгтэйчүүдийнхтэй төстэй байсныг стохастик үйлдэлч төвтэй загварууд (SAOM)-ын шинжилгээгээр тогтоожээ.

Гэвч судлаачид НСО-г заримдаа бүтэц төвтэй хандлага давамгайлж, соёл, утга, эрх мэдлийн асуудал орхигдох эрсдэлтэйг (Emirbayer & Goodwin, 1994) сануулсаар байна. Мөн сүлжээний мэдээлэл цуглуулахад зөвшөөрөл авах, оролцогчдыг бүрэн нууцлахад хүндрэлтэй. Хүмүүсийн үүсгэсэн сүлжээ, найз нөхдөөс хамаарч тухайн хүний зан төлөв тухайлбал спортоор хичээллэх, тамхи татах, сурлагын амжилт гаргах зэрэгт нөлөөлж байгааг үүгээр судалдаг. Цаг хугацааны өөрчлөлт болон сүлжээнд оролцогчдын харилцаа холбоос нь тогтмол биш зүйл. Байнга үүсэн бий болж эсвэл алга болж байдаг. Үүнийг нэг зургаар биш харин цуврал байдлаар өөрчлөгдөж буй хөдөлгөөнийг загварчлах шаардлага тулгарч байна. Ирээдүйд олон давхаргат ба динамик загварыг судлахдаа этнографийн нарийвчилсан судалгаатай хослуулж, мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах, сүлжээнд тэгш бус байдал хэрхэн бий болж буйг судлах шаардлагатай байна.

Хээрийн судалгааны бэлтгэл ажил

Бид судалгааны төлөвлөгөө гаргаж, өргөн хүрээний зорилгоо тодорхойлдог ч эдгээр зорилго нь очих газраа хүрсэний дараах явц дунд ихэвчлэн өөрчлөгддөг. Энэ нь бид тухайн газар тодорхой хугацаанд байж, нөхцөл байдлыг ойлгохоос нааш зөв асуулт юу болохыг урьдчилан мэдэх боломжгүй байдагтай холбоотой. Тиймээс судалгааны өмнөх шатанд арга зүйн нарийвчлал, газрын онцлогийг тодорхойлох зорилгоор урьдчилсан уулзалт, сургалтыг зохион байгуулсан. Судалгааны газар нутаг хүн амын бүтэц, амьжиргааны хэв маяг, нь судалгааны зорилготой уялдан сонгогдсон байв.

Бидний ажилласан “Эндоу” төсөл ойролцоогоор 30 гаруй орны хөдөө нутгуудаар хийгдэж буй судалгаа юм. Энэ нь Эдийн засгийн сүлжээ ба баялгийн тэгш бус байдлын динамик хэмээх ойлголтыг (энэ нэршлээс ENDOW гэх товчлол гарсан) ойлгоход чиглэж байна.¹ Тэдгээр орны дунд Монголын хөдөө нутаг багтсан бөгөөд Завхан, Хэнтий аймагт урт хугацааны судалгаа хийгдсэн билээ. 5-н жилийн зайтай хийгдсэн уг төслийн эцсийн хээрийн судалгаа 2023 онд Завхан аймагт харин 2024 онд Хэнтий аймагт өрнөсөн. Антропологийн баклавар, магистар, докторын түвшний оюутнуудаас бүрдсэн 8-9 хүнтэй баг судалгаанд оролцсон. Судалгааг чанарын болон тоон аргыг хослуулан авсан байдаг. Мөн дээрх судалгаа нийгмийн сүлжээний торлогийг гаргахад чиглэж байсан нь хамгийн чухал алхамуудын нэг байлаа. Төслийн хүрээнд тоон мэдээллийг цуглуулах зориулалттай онлайн платформ (ENDOW, n.d.) дээр мэдээлэл цуглуулах арыг ашиглаж байв. Үүний тулд төслийн зүгээс

¹ [Data Management · ENDOW](#)

4 ширхэг таблет болон дагалдах хэрэгслүүдийг өгсөн. Төслийн судалгааны явц нь бүгд нээлттэй ил тод байдаг.

Судалгаанд гарахаас өмнөх 2 хоногт бид арга зүйн сургалт - семинар хийдэг. Энэхүү семинарын үеэр судалгааны удирдагч багш маань очих газар, ашиглах техник, асуух асуултууд, хэрхэн мэдээллийг цуглуулах, нэгтгэх талаар дэлгэрэнгүй тайлбарласан сургалтыг ордог. Ингэснээр судалгааг үр дүнтэй, ёс зүйн болон соёлын хувьд мэдрэмжтэй байдлаар хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлдэг.

Сургалтын үеэр асуултуудаа нэгнээсээ асууж, хариулж үздэг. Оролцогчдод суурь мэдээлэл өгч, судалгааны асуултуудыг хэрхэн танилцуулах, үр дүнтэй асуух талаар хэлэлцэнэ. Судалгааны үйл явцын гол зорилго нь тухайн хүмүүс болон нийгмийг өөрсдийнх нь ухамсар, тайлбар, үзэл баримтлалтай нь хамт ойлгоход оршдог. Иймээс судалгааны асуултуудыг асуухдаа ямар нэгэн чиглүүлсэн өнгө аясгүй, оролцогчдын байр суурийг үгүйсгэхгүй, гажуудсан ойлголт үүсгэх эрсдэлгүй байх шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор асуултаа бие биедээ туршиж үзсэнээр асуултын хэлбэржилт, нөлөөллийн боломжит эрсдэлийг тодорхойлох боломж бүрдэнэ. Жишээлбэл манай судалгааны асуултууд дунд өвлөж авсан малын тоог асуудаг. Энэ тохиолдолд хүмүүс “тусдаа гарахдаа юу?” гэж тодруулах нь маш түгээмэл байсан. Тэгэхээр монголын соёлд ихэвчлэн өрх тусгаарлан гарахад аав ээж нь өөрсдийн малаас тасалж өгсөн малыг “өвлөж авсан мал” гэж ойлгох нь түгээмэл байна гэж үзээд тухайн хэсгийг асуухдаа тодруулж өгч байв.

Очих газрын тухай тодорхой мэдээлэлтэй байх ёстой. Тухайлбал Завхан, Хэнтий гэсэн хоёр аймгийн онцлогийг харах. Завхан аймгийн хувьд бидний гол судалгааны талбар Отгон сумд байрлах нэг баг байлаа. Отгон сум Завхан аймаг, Улиастай хотоос 130 км зайд оршдог алслагдсан сум юм. Гэвч Отгон сумаас цааш Отгонтэнгэр хайрхан байдаг тул жуулчид, ялангуяа уулчид тасардаггүй нутаг байсан. Тиймээс нутгийн эдийн засгийн сүлжээг ойлгохын тулд холбогдож байгаа бүх холбоосыг цогцоор нь харах шаардлагатай. Харин Хэнтий аймагт бид Баянхутаг сумд байрлах багт судалгаа хийсэн. Энэ удаад эсрэгээрээ аймгийн төвтэйгөө 22 км зайтай орших энэ сумын багт амьдардаг хүмүүс сум руугаа гэхээс илүү аймгийн төв рүү зорчих хөдөлгөөн илүү их байсан. Энэ нь зах зээлийн нөхцөл байдал илүү давамгайлахад тодорхой нөлөөлж байгаа нь ажиглагдаж байлаа.

Судалгааны талбар луу гарахаас өмнө шаардлагатай техник, материалын иж бүрэн бэлтгэлийг хангана. Уг бэлтгэл нь хоёр үндсэн хэсэгтэй. Нэгдүгээрт, судалгааны төслийн хүрээнд ашиглах албан ёсны тоног төхөөрөмж; хоёрдугаарт, чанарын судалгааны оролцон ажиглах явцад шаардлагатай бичлэг, тэмдэглэл хөтлөх хэрэгслүүд.

Төслийн хүрээнд хийгдэх асуулгыг мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс таблет төхөөрөмж дээр шууд шивж оруулна. Иймээс таблетийн ажиллагаа, бүрэн бүтэн байдал, түүнтэй холбоотой дагалдах хэрэгслийг (цэнэглэгч, олон төрлийн разетканд нийцэх

хувиргагч, уртасгагч гэх мэт) бүрэн бүрдүүлэх шаардлагатай. Судалгааны талбарын нөхцөлд сүлжээ тасрах боломж өндөр байдаг тул асуулгыг цаасан хэлбэрээр давхар бэлтгэн, шаардлагатай үед ашиглах боломжтой байдлаар авч явна. Энэ нь цаасан асуулгын хангалттай нөөц, мөн тэдгээрийг бөглөх хэрэгсэл болон хадгалалт, ангилалд шаардлагатай хавтас зэргийг багтаана.

Чанарын судалгаанд ашиглагдах техник хэрэгсэл нь дараагийн нэг багц бөгөөд антропологийн чиглэлийн чанарын судалгаанд ярилцлагын арга голлон хэрэглэгддэгтэй холбоотой. Ярилцлагын үргэлжлэх хугацаа дунджаар нэг цагаас хэдэн цаг хүрэх тохиолдол түгээмэл бөгөөд нэг оролцогчоос авагдах ярилцлага дор хаяж нэг цаг орчим үргэлжилнэ. Судалгааны явцад нэг судлаач дор хаяж 4–5 оролцогчтой ярилцалга хийх зорилготой байдаг тул олон цагийн аудио бичлэгийг найдвартай хадгалах хүчин чадалтай гар утас эсвэл зөөврийн компьютер шаардлагатай. Үүнтэй уялдан цэнэглэгч, зөөврийн цэнэглэгч, нэмэлт дата болон бусад дэмжих хэрэгслүүдийг бүрдүүлэх нь судалгааны тасралтгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болдог.

Хээрийн судалгааны эхний үе: Орон нутгийн ерөнхий мэдээлэл

Завхан аймаг 82.5 мянган км² нутаг дэвсгэртэй. Улаанбаатар хотоос аймгийн төв Улиастай хот хүртэл 1038 км зайтай. Сүүлийн үеийн (ойролцоогоор 2020–2021 орчим) тооллогоор Улиастай хотын хүн ам ойролцоогоор 16,580 хүн оршин суудаг гэж тоологджээ (Citypopulation, 2021). Улиастай хотоос Отгон сум хүртэл ойролцоогоор 128-130 км зам дагуу байрлалтай байна. Отгон сум нь Завхан аймгийн зүүн урд хэсэгт, Отгонтэнгэр хайрхан орчимд байрладаг. Завхан аймгийн зүүн захын сум бөгөөд сумын төвийг Хужирт гэнэ. 2021 оны хүн амын тооллогоор ойролцоогоор 2593 (National Statistics Office of Mongolia, 2021) хүн амтай гэж тоологджээ. Отгон сумын нутаг ихэвчлэн хөдөө, мал аж ахуй давамгайлсан; хүн ам багатай, хүн амын нягтрал маш бага (0.3-0.7 хүн/км²) (National Statistics Office of Mongolia, 2021).

Завхан аймагт бидний очсон сум, багийн хувьд мал аж ахуй давамгайлсан, хүн ам сийрэг тархалттай байсан. Миний ажиглаж байснаар өрхийн дундаж бүтэц нь нийтлэг гурван үеийн хамтын амьдралтай байсан. Багийн хувьд ерөнхийдөө ураг төрөл, саахалт айлууд хоорондын харилцаанд суурилсан байна. Гэвч Отгонтэнгэр хайрхан орчмын нутаг учраас зарим жилийн болон улирлын онцлог мөчлөгт үе таардаг. Энэ нь аялал жуулчлал ихсэх, төрийн тахилгат жил, уулчдын ирэх үе. Энэ үед давхар орлогын эх үүсвэр бий болдог.

Хэнтий аймаг нь нийт 80,325 км² нутаг дэвсгэртэй. 2021 оны байдлаар аймгийн хүн ам ойролцоогоор 79000 орчим байжээ (National Statistics Office of Mongolia, 2021). Аймгийн төв нь Чингис хот бөгөөд

Улаанбаатар хотоос ойролцоогоор 330 км зайд оршдог (Khentii aimag governor's office, 2023). Аймгийн эдийн засгийн бүтцэд хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуй давамгайл байр суурь эзэлдэг бөгөөд нийт эдийн засгийн гол салбарын нэг болдог (Mongolia Inc, 2022). Баянхутаг сум аймгийн төвөөс 22 км зайд байдаг, зүүн өмнөд хэсгийн сум юм. Баянхутаг сумын газар нутгийн хэмжээ ойролцоогоор 6,029 км² бөгөөд хүн амын нягтрал маш бага, 1 хүн/км²-ээс бага байдаг. 2021 оны статистикийн мэдээгээр Баянхутаг сумын хүн ам ойролцоогоор 2,515 байжээ (National Statistics Office of Mongolia, 2021).

Баянхутаг сум нь аймгийн төвтэй ойр байрладаг тул бидний очсон багийн оршин суугчид ихэвчлэн сумын төв рүү биш, шууд аймгийн төв рүү зорчих нь элбэг байв. Тус баг нь уулын, хойд, баруун гэсэн хэсгүүдэд хуваагддаг онцлогтой. Миний ажигласнаар тухайн бүс нутагт зах зээлийн харилцаа болон арилжаа наймаа мал аж ахуйтай хослон хөгжсөн, эдийн засгийн идэвхтэй бүс нутаг байлаа. Бидний очсон үед буюу зун, малын тоо харьцангуй цөөрсөн байв. Өвөл, хаврын улиралд тохиосон төмөр зудын улмаас олон малчин өрх малаа олноор нь хорогдуулсан нь үүнд голлон нөлөөлсөн бололтой. Магадгүй үүнтэй холбоотойгоор малчид ирэх намар болохоос өмнө малаа олноор нь бойнд тушааж байсан байх боломжтой юм.

Орон нутгийн удирдлагууд, орон нутгийн хөтөч

Судалгааны эхний шатанд орон нутгийн захиргаа болон холбогдох байгууллагуудтай урьдчилсан уулзалт хийж, судалгааны зорилго, хүрээг танилцуулсан. Аймгийн төвөөс сум, багийн түвшин хүртэл шат дараатай уулзалт хийснээр судалгаанд хамрагдах өрх, бүлгийг тодорхойлох боломж бүрдэв. Эдгээр уулзалтууд нь зөвшөөрөл авах төдий бус, орон нутагт итгэлцлийг бий болгох анхны алхам болсон юм. Аймгийн төвд хийсэн уулзалт илүү албан ёсны байсан бол багийн түвшинд дотночлох харилцаа давамгайлж байв.

Нийтдээ бид 20 хоногийн хугацаанд байрлаж ажиллахаар байлаа. Хөтөч сонгон ажиллуулах үйл явц нь судлаачдаас тодорхой хэмжээний урьдчилсан хайлт, зохион байгуулалт шаарддаг. Манай багийн хувьд Хэнтий аймагт өмнө нь хамтран ажиллаж байсан хөтөчтэй дахин хамтарсан бол Завхан аймагт өмнөх хөтөч татгалзсантай холбоотойгоор шинэ хүнтэй хамтран ажилласан. Хөтөч нь заавал тухайн орон нутгийн хүн байх шаардлагатай бөгөөд судлаачид болон судалгаанд оролцогчдын хооронд итгэлцлийн зууч болох үүрэг гүйцэтгэдэг. Судлаачийн гадны хүн гэдэг байр суурь нь орон нутгийн нийгэмд нэвтрэхэд тодорхой хязгаарлалт үүсгэдэг бол хөтөч тухайн орон зайн дотоод логик, нийгмийн харилцааны сүлжээг сайн мэддэгийнхээ ачаар судлаачид уг нийгэмд нэвтрэх боломжийг бүрдүүлдэг.

Ажлын эхний өдрийг голчлон зохион байгуулалтын бэлтгэл болон талбарын анхан шатны ажиглалтад зориулсан. Энэ хүрээнд

судалгааны баг тухайн орон зайн нийгэм, институцийн зохион байгуулалттай танилцаж, оршин суугчид, худалдаа үйлчилгээний цэгүүд, нутгийн захиргааны байгууллагууд, банк, соёлын төв, нийтийн гудамж талбай зэрэг орон нутгийн өдөр тутмын амьдралын гол зангилаа бүхий орон зайг ажиглав. Үүний дараа судалгааны баг аймаг, сумын удирдлагуудад судалгааны ажлын талаар албан ёсоор мэдээлж, судалгааны зорилго, хамрах хүрээг танилцуулна.

Ингэснээр судалгаатай холбоотойгоор үүсэж болзошгүй ташаа ойлголт, үл ойлголцлоос урьдчилан сэргийлэх, мөн судалгааны үйл явцыг ил тод, ёс зүйтэй байдлаар хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Рассел Бернард (2018) ч судалгааны бэлтгэл үе шатанд орон нутгийн удирдлагуудтай харилцаа тогтоож, тухайн газрын талаар тэдний тайлбарласан өнцгөөс ойлголттой болох нь найдвартай мэдээлэл цуглуулах үндэс болдог гэж тэмдэглэжээ. Уулзалтын үеэр судалгааны зорилго, чиглэл, ажлын төлөвлөгөөг танилцуулахад удирдлагуудын зүгээс таатай хандаж, судалгааны үйл ажиллагааг дэмжихээ илэрхийлэв. Тэд бидний очих газрын онцлог, байгаль, соёл, нийгмийн нөхцөл байдлын талаар цаг үеийн мэдээлэл өгч, аюулгүй ажиллагааны талаар тодорхой зөвлөмж өгөв. Энэхүү уулзалтаар очих сумынхаа цаг үеийн нөхцөл байдалтай танилцаж чадсан нь ажлын бэлтгэлийн чухал хэсэг болсон юм. Өдрийн төгсгөлд судалгааны баг дотоод зохион байгуулалтын хурал хийж, дараагийн өдрийн судалгааны төлөвлөгөөг гаргаж, техник хэрэгсэл, судалгааны материалын бэлэн байдлыг нягталж өнждөг.

Судалгааны ерөнхий арга зүй

Судалгааны үндсэн арга нь тоон мэдээлэл (хагас бүтэцтэй ярилцлага), оролцон ажиглалт, этнографийн ярилцлагын аргад тулгуурласан. Тоон мэдээлэлд үндэслэн төслийн хүрээнд үндсэн судлаачид сүлжээний зураглал (SNA) гаргах зорилготой юм. Эхний шатанд очсон газрынхаа нөхцөл байдалд дасан зохицох, оролцогчдын итгэлийг олж авах зорилгоор өрхийн түвшний ярилцлага, анхны ажиглалтыг хослуулан хийсэн. Судалгааны асуулт нь нийгмийн холбоо, итгэлцэл, хамтын ажиллагааны бүтэц хэрхэн бүрэлдэж байгааг төвд тавьсан юм.

Судалгаанд тодорхой тооны өрхийг хамруулан асуумжийн аргаар мэдээлэл цуглуулж, авсан өгөгдлийг таблет төхөөрөмж болон цаасан хувилбарт давхар бүртгэх зохион байгуулалтыг баримталсан. Судалгаанд нийт 80 өрхийг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь судалгаа хэрэгжсэн багийн өрхийн дийлэнх хувийг хамарсан түүвэрлэлт болж байсан. Судалгааны явцад хүн амын шилжилт хөдөлгөөн, нас баралт зэрэг нийгэм-хүн ам зүйн өөрчлөлтөөс шалтгаалан өмнөх судалгаанд хамрагдаж байсан зарим өрхүүд судалгаанд оролцох боломжгүй болсон байлаа. Ийм нөхцөлд багийн даргатай хамтран шинээр суурьшсан өрхүүдийг түүвэрт нэмж

хамруулж, судалгааны хамрах хүрээг хадгалах зохицуулалт хийсэн. Судалгаа нь урт хугацааны давтамжтай явагдсан тул зарим өрхүүд судалгааны багийн зарим гишүүдийг таньж байсан нь талбарын харилцаанд нөлөөлсөн хүчин зүйл байв.

Судалгааны талбар дахь ажил зохион байгуулалт тодорхой бүтэцтэй явагдсан. Бид товлосон баг дээр очоод хоёр хоёроороо хуваагдан, хөтчийн тусламжтайгаар айлуудад хүргүүлдэг байв. Заримдаа нэг машинаар дарааллан, заримдаа хоёр баг болон явдаг. Хөтөч болон удирдагч багш маань айлд очих бүрд судлаачдыг танилцуулж, судалгааны зорилго, утгыг товч тайлбарлан үлдээдэг нь оролцогчдын итгэлцэл үүсгэхэд чухал алхам болдог байв. Судалгааны эхний хэсэг нь асуумж хэлбэрийн асуулга бөгөөд 10 бүлэг, бүлэг бүр дотроо 10 орчим асуулттай байв. Гэвч талбарт хэрэгжүүлэх явцдаа энэ бүтэц хатуу “асуумж” гэхээс илүү малчдын өдөр тутмын туршлага, хандлагыг тайлбарлуулах хэлбэртэй болж ирдэг байв. Судлаачдын нэг нь таблет ашиглан хариултуудыг бүртгэж байх зуур нөгөө нь дэлгэрэнгүй сэтгэгдэл, ажиглалтыг тэмдэглэн авч, оролцогчийн өгүүлэмжийг нөхөж тэмдэглэдэг байсан нь чанарын болон тоон өгөгдөл хослуулсан ажиглалт гэж үзэхэд тохиромжтой.

Ийш тийшээ олон айлуудаар ордог учраас машинаар хүргэж, багаараа айлууддаа хуваарилагдан бууцгаадаг. Ингээд ойролцоогоор хамгийн сүүлчийн баг айл руу орж судалгаагаа эхэлж байх үед эхний баг судалгаагаа авч дуусаад ярилцлага хийж байдаг. Дараа нь эхний буулгасан багаасаа эхлээд түүж явсаар сүүлчийн баг дээр очиход яриагаа авч дуусч байдаг. Иймэрхүү зохион байгуулалтаар Хэнтий аймагт бидний хөтчийн ачаар хоёр машинд хуваагдаж явсан. Бидний очсон газар айлууд ихээхэн тарж нүүдэллэдэг онцлогтой байсан. Мөн хаана зусаж, буудалласныг нь мэдэхгүй байх тохиолдлууд их гарч байлаа. Тиймээс нэгээс нөгөө айл руу очиход хугацаа их зарцуулж байсан. Эхний өдрүүдэд бидний товлосон айлууд нүүчихсэн байх, эзэнгүй байх тохиолдлууд маш их байсан. Иймд Хэнтийд эхний өдрүүд маань хоёр хүртэлх айлаар л орж амжиж байв.

Чанарын судалгааны хүрээнд судлаачид оролцогчдын өдөр тутмын орчинд ойртон ажиллаж, албан бус ярилцлага, ажиглалт, хээрийн тэмдэглэл зэрэг аргыг хослуулан ашигласан. Үүний үр дүнд саахалт айл хоорондын харилцаа, бүтээгдэхүүнээ нийлүүлэх зах зээлийн сувгууд, харилцан туслалцах сүлжээ, малын бэлчээрийн хамтын ашиглалтын зохицуулалт зэрэг эмзэг, хувийн шинжтэй мэдээлэл цуглуулах боломж бүрдсэн. Ийм төрлийн мэдээлэл нь судалгааны ёс зүйн өндөр шаардлага дагуулдаг тул өгөгдлийн нууцлалыг чанд хадгалах, судалгаанд оролцогчдын аюулгүй байдал, тав тухыг хангаж буйгаа тодорхой тайлбарлах нь судалгааны салшгүй хэсэг байв. Энэхүү чанарын мэдээлэл нь тоон судалгааны үр дүнг нөхөж, тэдгээрийн цаадах утга учир, шалтгаан, орон нутгийн нөхцөлтэй хэрхэн холбогдож байгааг тайлбарлахад чухал үүрэг

гүйцэтгэсэн бөгөөд судалгааны дүн шинжилгээг илүү иж бүрэн, контекстэд суурилсан байдлаар хийх боломжийг бүрдүүлсэн. Хэдий тийм ч судалгаанд оролцож байгаа зарим хүмүүс тухайлбал малчид гайхаж, зарим хүмүүс 5 жилийн өмнө өөр хүмүүс ирж асуулт асууж байсныг тод санаж “5 жилийн өмнөхөөс нээх ч өөрчлөгдөөгүй дээ” хэмээж байв.

Судалгаа авах, өгүүлэмжийг тайлбарлах

“Өнөөдөр баг дээр ирснээс 3 дахь өдөр болж байна. Одоо л жоохон ойлгож эхэлж байх шиг байна. Ялангуяа Ч... гуайнд орсон нь их зөв юм боллоо гэж бодож байна. Энэ хавийнхны талаар бага зэрэг ярьж өглөө. Б... ахын ярьсан зарим зүйлээс зөрж байна. Энд нэг ченж байна, хүмүүс их ам муутай байдаг ч бүгдээрээ тэр хүнтэй холбоотой бололтой, тэр хүнтэй бид бүгдээрээ ярилцаж үзэхийг хүсч байна.”²

Судалгааны асуумжуудын хүрээнд хүмүүсийн хоорондын уялдаа холбоо, нийгмийн харилцааны бүтцийг ойлгохын тулд ялангуяа гүн ярилцлагыг ашиглан мэдээлэл цуглуулах нь түгээмэл байв. Бернард (2018)-ын тэмдэглэснээр бол хагас бүтэцтэй асуумжын зорилго тодорхой байдаг ч ярилцлагын үеэр судлаач асуултаас гаднах шинэ мэдээлэлд бэлтгэлтэй байх нь чухал гэж дурьдсан байдаг (х.165). Асуумжын эхний 4 бүлэгт тухайн өрхийн мэдээллийг хамруулна. Үүнд нь өрхийн өмнөх түүх болон аав ээж, эмээ өвөө мал хуйтай холбоотой асуумжууд бий. Энэ нь тухайн өрхийн нийгмийн сүлжээг гаргах эхний шат бөгөөд өрхүүд хоорондын нийгмийн сүлжээний өмнөх эсвэл уламжлагдаж ирсэн харилцаа холбоог гаргахад туслах юм.

Жишээлбэл нутгийн нэгэн чинээлэг малчин асуумжид оролцож байна гэж бодъё. Тэр малчин саяхан төрөөс зохион байгуулаад байгаа “шинэ хоршоо” хөдөлгөөнд элссэн айл байлаа. Хоршооны суурь зарчимд 9 хүртэлх “өрх айл” нэгдэж нэг хоршоо үүснэ гэж заасан байдаг (office.sme.gov 2021). Тухайн айл хоршоо болохдоо хэрхэн өрхүүдийг бүрдүүлснийг ойлгохын тулд бид өмнөх харилцааг мэдэх шаардлагатай болсон юм. Нутгийн “чинээлэг” гэсэн малчид ихэвчлэн бүлээрээ нутаглах нь бий. Түүнд нь өөрийн хүүхдүүд, туслах малчин, зарим үед хадмын талаас хамт зусах, намаржих нь элбэг байдаг. Тэгвэл туслах малчин нь уг айлд саяхан ирсэн үү, эсвэл аав ээжээс нь эхлэн тусалж байв уу, туслах малчин нь чинээлэг айлынхаа садангийн хүн үү эсвэл найз нөхдийн хамаарлаар танилцсан уу гэх мэт харилцааг анзаарах нь чухал. Гэвч судалгааны асуулгыг хэрхэн тэрхүү мэдээлэл рүү хөтлөх вэ гэдэг судлаачийн боломж нөөцөөс ч бас ихээхэн хамаардаг. Учир нь 40 орчим асуулга дууссаны дараа үргэжлүүлэн яриа өгөхдөө дуртай байх хүмүүс ховорхон тохиодог.

² Хээрийн судалгааны тэмдэглэл, 2023 оны 8 сарын 13

Судалгаанд оролцогчид зөвхөн мэдээлэл өгөх бус, харин утга бүтээлцэж буй идэвхтэй үйлдэгчид (actors) юм. Стохастик үйлдэлч төвтэй загвар (SAOM) нь ийм сүлжээг хувь хүмүүсийн зан үйл, харилцааны хам өөрчлөлттэй уялдуулан тайлбарлахад өргөн хэрэглэгддэг (Snijders 2001; Snijders & Steglich 2010). Энэхүү загвар нь сүлжээний бүтэц хэрхэн бий болж, тасарч, дахин бүрэлдэж байгааг оролцогчдын хэнтэй харилцаа холбоотой байх сонголт болон зан үйлийн өөрчлөлттэй холбон загварчилдаг.

Оролцогч бүрийн өгүүлэмжийг тайлбарлахад тэдний сүлжээнд эзэлж буй байрлал, холболтын тоо хэмжээ, нөлөөллийн түвшинг анхаарах нь чухал байдаг. Ан (2022)-ын тэмдэглэснээр, сүлжээнд илүү олон хүнтэй холбогдсон, “төвийн байрлалтай” хүмүүс нь мэдээлэл түгээх, итгэлцэл бий болгох үүргээрээ илүү нөлөөтэй байдаг тул чанарын судалгаанд тэднийг илүү анхаарч шинжлэх шаардлагатай. Судалгааны явцад энэ нь ярианы идэвх, бусдад нөлөөлөх байрлал, мэдээллийн урсгалын төвд байх байдлаар илэрч байв. Жишээлбэл бүлэг асуулт дунд мал сүргийн тоо толгой, хувь хүний өмчтэй холбоотой асуултууд бий. Хүмүүс энэ хэсэгт хариулж дадсан хэв маягтай хариулт өгдөг. Яагаад гэвэл малчдын хэлж байгаагаар бол үе үе олон улсын байгууллагуудаас ирж энэ мэтийн судалгаа авдаг ч дараа нь ямар нэг хариу, үр дүн байдаггүй. Тухайлбал “... оны ... сараас ... оны мөн үе хүртэлх малын тоо, бэлчээрийг хувьчлах, эзэмшүүлэх, өмчлүүлэхийн аль нь зөв гэж үзэж байна вэ, хашаа саравч, өвөлжөөний байрлал, өмчийн бүртгэл буюу хэдэн машинтай вэ? (болон бусад), та үүнийгээ хэдээр үнэлэх вэ?”³ гэх мэтчилэн орлогын эх үүсвэртэй холбоотой асуулт байдаг. Энэхүү нөхцөл байдлыг сүлжээний онолын үүднээс харвал, оролцогчдын хариулт нь мэдээлэл дамжуулалтын итгэлцлийн сүлжээний нэг хэсэг болж хувирна. Хэрэв сүлжээний итгэлцэл сул байвал судалгаанд оролцогчид илүү албан хариулт өгөх хандлагатай байдаг (An 2022) бол итгэлцэл бий болсон тохиолдолд илүү дэлгэрэнгүй, хувийн өгүүлэмжүүд гарч ирдэг. Иймээс тоон хэлбэрийн өгөгдөл ч гэсэн соёлын утгатай, харилцааны нөлөөнд оршдог гэж үзэж болно. Биднийг ярилцалга болон судалгаа авч байх эхний өдрүүдэд хүмүүс албан хариулт өгөх нь их байсан ч сүүлийн өдрүүдэд тэд тэмдэглэлийн дэвтэрээ үзүүлэх, тайлбарлаж ярих нь илүү түгээмэл болсон байсан юм.

Иймээс өгүүлэмжийг буюу хүний хэлж буй зүйлсийг зөвхөн хэлний утга, агуулгаар нь бус, тухайн ярилцлага өрнөж буй нийгмийн сүлжээний бүтэц, эрх мэдлийн байрлал, итгэлцлийн түвшинтэй холбон ойлгох шаардлагатай гэж үзсэн. Энэ утгаараа судалгааны өгөгдлийг тайлбарлах үйл явц нь тоон болон чанарын арга зүйн огтлолцол дээр суурилсан утга бүтээх үйл явцыг сүлжээний орчны дотор ойлгох оролдлого байв. Өөрөөр хэлбэл нэг малчин “бид одоо

³ ENDOW (2023) төслийн 8-р бүлгийн асуултаас

урьдынх шиг хамтдаа малаа хариулдаггүй болсон” гэж ярих нь зүгээр нэг баримт биш, харин хамтын амьдралын өөрчлөлтийн тухай өгүүлэмжийн хэлбэрээр илэрч байгаа соёлын санаа юм (Geertz 1973).

Этнографийн ярилцлага, оролцон ажиглалт

Бид дараагийн алхам буюу хоёроос гурав хоног оролцон ажиглалт хийхийн тулд эрчимтэй ажиллав. Өдөр бүр эртлэн босож, цайгаа ууж, айлуудаа товлоод машиндаа сууцгаана. Эхний өдрүүдэд бидний товлосон айлууд нүүчихсэн байх, эзэнгүй байх тохиолдлууд маш их байсан. Тухайлбал Хэнтийд эхний өдрүүдэд хоёр хүртэлх айлаар л орж амжиж байв. Нөхцөл байдал нэгэнт ийм байсан тул бид зарим товлосон хүмүүстэйгээ уулзаж ярилцалга хийж амжсан. Ярилцлага дууссаны дараа дараагийн айлаа хаана буудаллаж байгааг нутгийн хүмүүсээс сураглан хөөж очих үйл явц нь хөндлөнгийн ажиглалт хийхэд хамгийн тохиромжтой үе байв. Энэ үеэр орон нутгийн иргэдийн хоорондын харилцааны бүтэц, мэдээлэл дамжуулах сүлжээ, итгэлцлийн төвлөрөл тод илэрч байлаа.

Зарим хүн бусдаас илүү сайн мэдээлэлтэй, хэн хаана байгааг яг таг хэлж чаддаг бол зарим нь мэдэхгүй эсвэл мэдсэн ч хэлэхээс татгалзах хандлагатай байсан нь сүлжээний доторх мэдээллийн урсгалын чиглэл ба хаалтыг харуулж байна (Granovetter 1973; Burt 1992). Нийгмийн сүлжээний онолын үүднээс авч үзвэл, ийм нөхцөлд мэдээллийг хамгийн түрүүнд, хамгийн найдвартай өгч буй хүмүүс нь төвийн байрлалтай оролцогчид (network hub) юм. Тэдгээр хүмүүсийн мэдээлэл бусдын хувьд “итгэлтэй эх сурвалж” болж, орон нутагтаа зуучлалын үүргийг гүйцэтгэдэг (Burt 1992). Харин зарим иргэдийн мэдээлэл хязгаарлагдмал, эсвэл бусдад хүрэхдээ удаан байдаг нь сүлжээний захын оролцогчид (peripheral actors)-ын шинжийг илэрхийлж байж болно. Ийнхүү талбар дахь өдөр тутмын хөдөлгөөн, хүмүүсийн хоорондын “сураглах” үйл явц өөрөө орон нутгийн нийгмийн сүлжээний динамикийг дүрслэх бодит туршлага болдог. Судлаачийн хувьд энэ бол асуумжаар илэрдэггүй, харин ажиглалтаар илэрдэг сүлжээний амьд бүтэц юм.

Судалгаа дуусаад бидэнд оролцон ажиглалт хийж болох ганц л өдөр байсан. Оролцон ажиглалт гэдэг нь судлаач өдөр тутмын амьдралд нь хамт оролцож, тэдний хийж буй зүйлийг хийж үзэн, ярилцаж, харилцаж байж тухайн хүмүүсийн туршлага, утга, логикийг дотроос нь ойлгох арга юм. Хэдий ганцхан өдөр байсан ч бид үр дүнтэйгээр харилцан ярилцаж, мал хуй хашингаа мэдээлэлээ цэцэгтэйгээр цуглуулж чадсан. Хэнтийд байхад айлууд гурван хэсэгт хуваагдаж бууцгаасан байв. Харин Завханд бол зүүнээс баруунд самнах маягтай айлуудаар орсоор дуусгаж байсан билээ. Завханд бид оролцон ажиглалт хийх 4 хоног гаргаж чадсан юм. Энэ 4 хоногийг хоёр айлд хоёр өдөр буухаар төлөвлөв. Эхний айл маань багийн төв хавьцаа зусаж байсан,

настай хоёр хөгшнийг тойрсон гал байлаа. Өмнөх өдрүүдэд судалгаа авахаар буусан байсан тул тэд биднийг таньж байв.

“эхний айл бол Ч... гуайнх байв. Хамгийн аюул багатай багийн төвтэй ойрхон дажгүй байрлалтай. Гэвч одоо юу болдог болдоо гэсэн бодлоосоо болж эхэндээ их л эвгүйрхэж байсан. Бид хоёр айлдаа буугаад цүнх саваа янзлаад сууцгаав. Шууд л ямар нэг зүйл ярьчих гэхээр эвгүйрхэж, айлын хүүхдүүд биднийг их сонирхож байлаа. Би гэр дотор аарц буцалган сууж байх хооронд Заяа саалин дээр байгаа хоёр хөгшинтэй ярилцаж байв. Гэрийн ажлыг нь нугалалцаж өгсөнд баяртай байсан айлын эгч биднийг тав тухтай байлгах гэж хичээж байх шиг. Өнөөдөр айлынд шууд л буучихсан учир эвгүйрхсээр л байсан. Ингэсээр нилээн оройхон орондоо орцгоож бид шинэ хүн учраас танилцах маягтайхан л өнгөрцгөөлөө.”⁴

Бидэнд хоёр хоног даанч хангалттай байсангүй дараагийн айл руугаа явах болсон. Тэд бидэнд сайн хандаж дараа жил ахин ирэхийг урьж байв. Дараачийн айл маань харин бидэнд дурамжхан байсан тул бид холбоо тогтооход үнэхээр хүндрэлтэй байсан. Энэ талаар:

“...Өглөө эртлэн босоцгоож бид хоёр хажуу гэрт эмээ дээр орж ярилцлага авахаар болов. Өчигдөр биднийг орж ирэхэд хальтхан орж ирчихээд гарсан болохоор энэ удаа биднээс дөлж, тухгүй санагдуулсан болов уу. Харин өглөө ярилцахаар орсны дараа асуулт болгонд мэдэхгүй гэх нь олон байсан тул бидэнд ч бас эвгүй санагдаж нэг их удалгүй гарцгаасан юм. ярилцах үед эмээ бидэн лүү биш охин луугаа л харж яриад байсан нь холбоо тогтооход бэрх байлаа. ... Оройхон бид тугал эвлэгэж зэлэн дээр ярилцаж зогсов. Тэр үед харин эмээ нилээн дажгүй болж ирсэн нь биднийг ядаж л ажил хийж чаддаг хүүхдүүд байна гэж хальтхан цухуйлгав.”⁵ гэж тэмдэглэж үлдээжээ.

Энэхүү ажиглалтаас харахад судлаач болон орон нутгийн оролцогчдын хоорондын харилцаа анхандаа сул холбоо хэлбэртэй байсан. Эмээгийн “мэдэхгүй” гэх хариулт, шууд харилцааас зайлсхийх байдал нь итгэлцэл хангалтгүй, бид хэтэрхий тулгаж эсвэл гэнэт хэт их зүйл асуусан нь оновчгүй байсныг илтгэнэ. Оролцон ажиглах хоёр том стратеги байдаг: ил тод, идэвхитэй байх болон идэвхигүй үл мэдэгдэх байдал юм. Бидний хувьд тэрхүү айлд очсноороо ажиглалт, судалгаа хийх нь ойлгомжтой байсан хэдий ч шууд ярилцлага авах гэж оролдон хэт идэвхи чармайлт гаргасан нь тэр хүмүүсийг тухгүй байдалд оруулсан байжээ. Энэ нь бидний алдаа болсон юм. Гэвч хэт их чармайлт гаргахаа багасгаж, өдөр тутмын амьдралд нь тусалж эхэлснээр нээлттэй болсон нь алдааг залруулж чадсан. Энэхүү өөрчлөлт нь чанарын судалгаанд өдөр тутмын амьдралд оролцох үйлдэл зүгээр туслах ажил биш гэдгийг харуулж байгаа юм.

⁴ хээрийн тэмдэглэл, 2023 оны 8-р сарын 16

⁵ хээрийн тэмдэглэл, 2023 оны 8-р сарын 16

Айлд хамт хонож, өдөр тутмын амьдралд нь оролцох явцад хамгийн эмзэг тусдаг зүйл бол тэмдэглэл хөтлөх үеүүд байв. Хэн нэгэн гаднын хүн өөрсдийнх нь дэргэд сууж, амьдралынх нь тухай анзаарч бичиж байх нь оролцогчдын хувьд зайлшгүй тухгүй байдал, болгоомжлол төрүүлдэг. Гэвч хээрийн тэмдэглэл бичих, тэднээс суралцаж байгаа гэдгээ мэдэгдэх нь хамгийн зөв сонголт байдаг (Bernard 2018). Энэ нь ёс зүйн үүднээс ч тэр оновчтой сонголт мөн. Гэхдээ судлаачын хувьд хэд хэдэн төрлийн тэмдэглэлтэй байх хэрэгцээ бий. Заримдаа тэмдэглэлээ харуулах, сонирхуулах шаардлага гарвал энэ их тустай байдаг. Завханд байхад нэг хөгшин нь бидэнд “социализмын үед даргыг орж ирэхээр биеээ барьж дээлийн бүсээ чангалдаг байлаа, одоо хүүхдүүдийн хажууд бас бүсээ чангалах нь уу дээ”⁶ гэж шоглож байсан удаатай. Гэтэл нөгөө талаас бидэнд тэмдэглэл судалгааны анализид чухал нөлөөтэй байдаг.

Судалгааны боловсруулалт, анализ хийх

Судалгаанаас буцаж ирээд хийх зүйл судалгаанд явахаас хамаагүй их байдаг. Статистик анализыг үл оролцуулан, ердөө текст анализ гэхэд л хэд хэдэн үе шаттай. Хээрийн тэмдэглэл, ярилцалга зэргээ ахин цэгцэлж, цуглуулсан бүх төрлийн мэдээлэл ярилцлагын аудио бичлэг, хээрийн тэмдэглэлийн дэвтэр, гэрэл зураг, асуумжийн хариултууд бүгдийг нь системтэйгээр боловсруулж эхэлсэн. Эхний шатанд ярилцлагын аудио бүрэн шивж, оролцогчдын хэллэг, дууны өнгө, түр зогсолт зэрэг паралингвист элементүүдийг (paralinguistic features) аль болох хэвээр нь буулгадаг. Энэ нь өгүүлэмжийн утгыг илүү гүнзгий ойлгох, оролцогчдын сэтгэлзүйн болон нийгмийн байрлалыг илрүүлэхэд чухал юм. Хээрийн тэмдэглэлдээ үйл явдлуудыг цаг хугацааны дарааллаар нэгтгэн, тухайн өдөр бүрийн үйл явдлын логик дараалал, судлаачийн байр суурь, сэтгэгдэл, эргэцүүллийг тусад нь ялган бичдэг. Ингэснээр өгөгдлийг зөвхөн мэдээллийн түвшинд бус, бодит байдлыг ойлгох нөхцөл бүрдэнэ.

Дараагийн шатанд өгөгдлийг сэдэвчилэн кодолж, давтагдан гарч ирсэн сэдвүүдийг ангилсан. Өөрөөр хэлбэл “итгэлцэл ба мэдээллийн урсгал”, “өрхийн дотоод харилцаа”, “хоршооны бүтэц дэх оролцоо”, “нийгмийн хил ба дотно холбоос” гэх мэтээр түлхүүр үг болгон кодлох юм. Браун ба Кларк (2006)-ийн тодорхойлсноор, ингэж ангилах нь судлаачид өгөгдлөөс сэдвийг механикаар гаргахаас илүү утгын түвшинд, утгад тулгуурлан ангилал хийх боломж олгодог.

Эдгээр ангилал анхан шатны кодчилал гэхэд болно. Дараа нь холбогдох өгөгдлүүдийг дэд бүлгээр нэгтгэн, оролцогчдын хоорондын харилцааны хэлбэр, мэдээлэл дамжуулалт, итгэлцлийн түвшинг харьцуулсан. Төслийн судалгааны хувьд оролцогчдын хоорондын

⁶ хээрийн тэмдэглэл, 2023 8-р сар

дотно, сул холбоосуудыг Грановеттер (1973)-ийн “сул холбоо” (weak ties) онолтой уялдуулан тайлбарлаж болно. Түүнээс гадна Бөрт (1992)-ийн онолын загвар болох бүлэг хоорондын завсар (structural holes) хэр их байна, түүнийг хэн хэн холбох үүрэг гүйцэтгэж байгаа зэргийг гаргах зэрэг онолын хүрээнд задлан шинжлэх боломжтой. Жишээ нь Завхан аймаг дах ченж ноолууртай холбоотой бүх л сүлжээнд дурьдагдаж байсан нь дээрх завсарын холбогч, зуучлагч болж байгаа юм. Гэхдээ үүнээс илүүтэй авсан энэ судалгааны мэдээллийг өөрийнх нь байгаагаар шинжлэн задлах, зүй тогтлыг гаргаж ирэх нь илүү чухал ач холбогдолтой. Нутгийн иргэдийн хооронд мэдээлэл хэрхэн дамждаг, ямар оролцогчид илүү итгэлтэй мэдээлэлийн гүүр болж байгааг тодорхойлохдоо зарим онолын суурийг ашиглаж болох ч тэдгээр мэдээллүүд өөрөө бас нэгэн онолын гаргалгаа, үзэгдэл байж болдог.

Өгүүлэмжийн түвшинд, оролцогчдын ярианд илэрч буй утга, үнэлэмж, туршлагын давтамж, өгүүлэмжийг задлан шинжлэл хийнэ. Рейсман (2008)-ийн үзэж байгаагаар, өгүүлэмжийг шинжилнэ гэдэг нь ярилцлагын текстийг зөвхөн хэлэмжийг дарааллаар нь буулгах биш, тухайн хүний нийгмийн орон зай, эрх мэдлийн байрлалыг тухайн хүнийхээ байр суурьтай холбон тайлбарлахад чиглэдэг. Судалгаанд оролцогчдын хариу үйлдэл, судлаачийн нөлөөлөл, мэдээлэл авах орчны харилцааг үнэлэх замаар өгөгдлийн найдвартай байдал, ёс зүйн хэмжүүрийг баталгаажуулсан. Тиймээс мэдээллийг боловсруулах нь зөвхөн ярилцлага бичвэр болгох үйл явц бус, харин өгөгдөлд орших утгыг дахин тайлбарлах шат байв.

Дүгнэлт

Завхан ба Хэнтий аймагт хийгдсэн хээрийн судалгааны материалыг ашиглан чанарын судалгааны арга зүй, этнографийн ярилцалга, тоон өгөгдлийг тайлбарлах, нийгмийн сүлжээг хэрхэн гаргах талаар үе шаттай задлахыг оролдлоо. Нийгмийн шинжлэх ухаанд судалгааны хоёр үндсэн чиг хандлага: чанарын ба тоон арга зүй нь өөр өөр зорилго, хандлагатай боловч хоёул нийгмийн үзэгдлийг илүү цогц ойлгоход зайлшгүй шаардлагатай. Тоон судалгаа нь хэмжих боломжтой үзүүлэлт, хувь хэмжээ, хамаарлыг статистик аргаар тодорхойлдог бол чанарын судалгаа нь тухайн үзэгдлийн утга, туршлага, соёлын контекст-ийг ойлгох зорилготой байдаг (Creswell & Plano Clark 2018). Тоон судалгааны давуу тал нь ерөнхий дүр зургийг харуулж, өргөн хүрээнд дүгнэлт гаргах боломж олгодог бол чанарын арга нь тухайн дүгнэлтийн цаадах нийгмийн утга, хүний туршлага, эрх мэдлийн харилцааг илүү гүнзгий судлах давуу талтай.

Эдгээрийн ялгаа нь судлаачийн байр сууринаас ч харагддаг. Тоон судалгаанд судлаач ажиглагчийн байрлалтай, харин чанарын судалгаанд судлаач оролцогчийн байрлалд шилжиж, утга бүтээлцэх үйл явцад ордог (Denzin & Lincoln 2011). Гэвч энэ хоёр арга хоорондоо

өрсөлдөгч бус, харин нөхөх шинжтэй гэж үзэх нь оновчтой. Бриман (2006)-ийн тэмдэглэснээр, нийгмийн үзэгдлийг илүү бодитоор ойлгохын тулд тоон өгөгдлөөр “юу болж байна вэ” гэдгийг тодорхойлж, чанарын өгөгдлөөр “яагаад тэгдэг вэ” гэдгийг тайлбарлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тоон судалгаа хариултын өргөн цар хүрээ, чанарын судалгаа гүнзгий утга өгдөг.

Энэ хослолыг нийгмийн сүлжээний арга зүй (НСА)-тэй нэгтгэх нь нийгмийн харилцааг илүү нарийн түвшинд задлан шинжлэх онцгой боломж бүрдүүлж байна. НСА нь хүмүүсийн хоорондын холбоо, итгэлцэл, мэдээллийн урсгалыг торлог бүтэц (network structure) хэлбэрээр харуулдаг бөгөөд оролцогч бүрийг идэвхтэй “үйлдэгч” (actor) гэж үздэг (Scott 2017). Энэхүү арга нь тоон болон чанарын өгөгдлийг хослуулан сүлжээний төвлөрөл, захын оролцогчдын байрлал, мэдээлэл дамжуулах зам зэргийг илрүүлэхэд тустай. Жишээлбэл, Грановеттер (1973)-ийн онолоор сул холбоосууд нь шинэ мэдээлэл дамжуулахад чухал үүрэгтэй. Бөрт (1992)-ийн дэвшүүлсэн “сүлжээн дэх завсар” (structural holes)-ын тухай онолын хувьд сүлжээнд хоорондоо холбоогүй бүлгүүдийн хооронд үүссэн завсрыг холбож чадсан хүмүүс зуучлалын байрлал эзэлж, мэдээлэл болон нөөцөд давуу хандалттай болдгийг харуулдаг.

Эдгээр онол нь тоон өгөгдлөөр сүлжээний бүтэц, нөлөөллийн төвлөрлийг тодорхойлохын зэрэгцээ, этнографийн чанарын өгөгдлөөр тухайн холбоосуудын итгэлцэл, соёлын логик, харилцааны утгыг тайлбарлахад тохиромжтой суурь болдог. Этнографийн оролцон ажиглалт нь харин энэ торлогийг амьд харилцааны түвшинд судлах нөхцөл бүрдүүлж байгаа юм (Hammersley & Atkinson 2007). Судлаач этнографийн оролцон ажиглалтын аргыг тодорхой судалгааны арга барил болгон ашигласнаар хүмүүсийн хоорондын харилцааг зөвхөн асуумжаар бус, харин өдөр тутмын хамтын оролцоогоор дамжуулан мэдэрч, итгэлцэл, зөрчил, мэдээлэл дамжуулалтын хэлбэрийг ойлгож чадна. Энэ нь чанарын болон тоон өгөгдлийг холбох гүүр болж, судалгааг илүү амьд, соёлын утгатай, бодит нөхцөлд суурилсан болгодог.

Гэвч арга зүйн хувьд тодорхой судалгааны хоосон орон зай ажиглагдаж байна. Нэгдүгээрт, нийгмийн сүлжээний арга нь бүтэц төвтэй хандлага давамгайлсан тул оролцогчдын дотоод сэтгэлзүй, соёлын утга, эрх мэдлийн тэгш бус байдлыг хангалттай тусгаж чадсангүй. Судалгаанд оролцогчдын дуу хоолой, сэтгэлзүйн мэдрэмж, ёс зүйн шийдвэрийн нарийн төвөгтэй байдал нь этнографийн өгүүлэмжид тусгагдсан боловч системтэй аналитик түвшинд гүнзгийрүүлээгүй байна. Хоёрдугаарт, сүлжээний торлог гаргахдаа оролцогчдын нэр, холбоосыг ил тод тэмдэглэх шаардлага нь мэдээллийн нууцлал ба ёс зүйн зөрчлийн эрсдэлийг дагуулж байгаа ч, судалгаанд энэ асуудлыг онолын түвшинд шүүмжлэн хэлэлцээгүй байна. Гуравдугаарт, оролцон ажиглалт нь мэдээллийн чанарыг

сайжруулахад үр дүнтэй байсан ч, судлаачийн оролцооны нөлөөллийг системчилсэн байдлаар дүгнээгүй, өөрөөр хэлбэл ажиглагчийн нөлөөллийг илүү нарийвчлан тусгах шаардлагатай.

Эцэст нь, “Мэдээллийн чанарыг сайжруулахад оролцон ажиглах арга зүй” нь нийгмийн сүлжээний анализийг антропологийн судалгааны хээрийн туршлагатай холбосон шинэлэг арга зүйн оролдлого бөгөөд цаашид нийгмийн харилцааны сүлжээг соёл, эрх мэдэл, ёс зүй, утга агуулгын огтлолцолд судлах онолын шинэ орон зайг нээж байна.

Талархал

Судалгаанд минь тусалж дэмжиж, хүүхэд шигээ хайрлаж, зааж сургасан малчин түмэн Та бүхэндээ маш их баярлалаа. Цинцинати их сургуулийн “Эдийн засгийн сүлжээ, баялагын тэгш бус байдлын өөрчлөлт” (NSF 2218860, 2218861) судалгааны төсөлд талархал илэрхийлье.

Ном зүй

- An, W., et al. 2022. “Network Centrality and the Credibility of Information Sources.” *Journal of Social Structure* 23 (2): 1–18.
- Bernard, H. Russell. 2018. *Research Methods in Anthropology: Qualitative and Quantitative Approaches*. 6th ed. Lanham, MD: Rowman & Littlefield.
- Braun, Virginia, and Victoria Clarke. 2006. “Using Thematic Analysis in Psychology.” *Qualitative Research in Psychology* 3 (2): 77–101.
- Bryman, Alan. 2006. “Integrating Quantitative and Qualitative Research: How Is It Done?” *Qualitative Research* 6 (1): 97–113.
- Burt, Ronald S. 1992. *Structural Holes: The Social Structure of Competition*. Cambridge, MA: Harvard University Press.
- Byambabaatar, I., and Emily T. Yeh. 2016. “Ephemeral ‘Communities’: Spatiality and Politics in Rangeland Interventions in Mongolia.” *Development and Change* 47 (4): 866–888.
- Byambajav, D. 2010. “Informal and Formal Networks in Post-Socialism: A Synthetic Analysis of Access to Networks in Mongolia.” *Journal of Contemporary Asia* 40 (1): 43–64.
- City Population. 2021. “Population Statistics of Uliastai City.” Accessed May 8, 2026. <https://www.citypopulation.de>.
- Creswell, John W., and Vicki L. Plano Clark. 2018. *Designing and Conducting Mixed Methods Research*. 3rd ed. Thousand Oaks, CA: Sage.
- Denzin, Norman K., and Yvonna S. Lincoln, eds. 2011. *The SAGE Handbook of Qualitative Research*. 4th ed. Thousand Oaks, CA: Sage.
- Duque, R. L. 2010. “Catherine Kohler Riessman (2008). Narrative Methods for the Human Sciences.” *Forum: Qualitative Social Research* 11 (1). Berlin: Freie Universität Berlin.

- Geertz, Clifford. 1973. *The Interpretation of Cultures*. New York: Basic Books.
- Granovetter, Mark S. 1973. "The Strength of Weak Ties." *American Journal of Sociology* 78 (6): 1360–1380.
- Hammersley, Martyn, and Paul Atkinson. 2007. *Ethnography: Principles in Practice*. 3rd ed. London: Routledge.
- Khentii Aimag Governor's Office. 2023. "Regional Introduction and Statistics." Accessed May 8, 2026. <https://khentii.gov.mn>.
- Монгол Улсын Их Хурал. 2021. *Хоршооны тухай хууль*.
- National Statistics Office of Mongolia. 2021. "Population of Mongolia by Region, Aimag, and Capital City." Accessed May 8, 2026. <https://1212.mn>.
- Redhead, Daniel. 2022. "Social Hierarchies and Social Networks in Humans." *Philosophical Transactions of the Royal Society B* 377 (1845): 20200440.
- Riessman, Catherine Kohler. 2008. *Narrative Methods for the Human Sciences*. Thousand Oaks, CA: Sage.
- Scott, John. 2017. *Social Network Analysis*. 4th ed. Thousand Oaks, CA: Sage.
- Snijders, Tom A. B. 2001. "The Statistical Evaluation of Social Network Dynamics." *Sociological Methodology* 31 (1): 361–395.
- Snijders, Tom A. B., G. G. van de Bunt, and Christian E. G. Steglich. 2010. "Introduction to Stochastic Actor-Based Models for Network Dynamics." *Social Networks* 32 (1): 44–60.
- Sneath, David. 1993. "Social Relations, Networks and Social Organisation in Post-Socialist Rural Mongolia." *Nomadic Peoples* 33: 193–207.